



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/187

Булган сум

┌ Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ┐
зардлын хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.8 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал”-ын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга)-т, Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

3. “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал” зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу тухай бүр нь аймгийн орон нутгийн төсвийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010247

03 дугаар сарын 12-ны өдрийн А/187 дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ТЭЗҮ зөвлөх үйлчилгээ, ажлын зураг төсөв боловсруулах зардлын хуваарь

№	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөл боловсруулах зардал	Тайлбар: Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 108 тоот тушаалаар баталсан "зураг төслийн ажлын жишиг үнэ" /БД 81-16-20/-ийг үндэслэл болгов.
Барилга			
1	Орхон суманд нэг маягын ерөнхий боловсролын 240 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, спорт заалны зураг төсөв холбох	100,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. БТХУБайцаагчийн дүгнэлттэй.
2	Могод сумын төвд нэг маягийн 10 ортой эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв холбох	74,363,640.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. БТХУБайцаагчийн дүгнэлттэй.
3	Мал эмнэлгийн лабораторийн шинэ барилгын аймгийн оролцооны хөрөнгө	15,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. БТХУБайцаагчийн дүгнэлттэй.
<i>Хэсгийн дүн</i>		189,363,640.0	
Их засвар			
4	Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн барилгын их засварын ажил	30,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
<i>Хэсгийн дүн</i>		30,000,000.0	
Инженер геологи, дэвсгэр зураг, паспортжуулах, бусад зардал			
5	Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн төлөв байдалд нарийвчилсан үзлэг хийх.	20,000,000.0	Аймгийн инженерийн хийцтэй нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжуудад үнэлгээ хийнэ.
6	Аймгийн хөгжимт жүжгийн театрын барилгын ажлын зургийн төсөв шинэчлэх	15,200,000.0	Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн А/435 тоот захирамжийг санхүүжүүлэх зардал
7	Булган сумын 3 дугаар сургуулийн 110 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын зургийн төсөв шинэчлэх	13,636,360.0	Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн А/435 тоот захирамжийг санхүүжүүлэх зардал. Магадлалын төлбөр болох 1.363.640 төгрөгийг 2025 онд өгсөн

8	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын лабораторийн барилгын ажлын зургийн төсөв шинэчлэх	6,800,000.0	Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн А/435 тоот захирамжийг санхүүжүүлэх зардал
9	2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний инженер геологийн зардал	17,000,000.0	3 барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх инженер геологийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
10	2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 1:1000 масштабтай геодези, дэвсгэр зураг боловсруулах зардал	3,000,000.0	3 барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх инженер геологийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
11	2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техникийн нөхцөлийн зардал	5,000,000.0	4 барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх инженер геологийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
Хэсгийн дүн		80,636,360.0	
Нийт дүн		300,000,000.0	Төсөвт өртөг

===oOo===